



МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ
УЛСЫН КОМИССЫН АКТ

2024 оны 10 дугаар сарын 01

Дугаар ЦТР-01

Улаанбаатар хот

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн
“Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв”-ийг
ашиглалтад хүлээн авах тухай

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Уурхай, уулын үйлдвэрийн нэр, байршил, хүчин чадал, ашигт малтмалын төрөл, хөрөнгө оруулалт, ажиллагсдын тоо:
 - Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв;
 - Хүчин чадал: 20.0 сая.тн;
 - Ажлын байр: Нийт 135 хүн;
 - Хөрөнгө оруулалтын хэмжээ: Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 313.5 тэрбум төгрөг;
 - Улс, орон нутгийн төсөвт: Төслийн хугацаанд 552.1 тэрбум төгрөг.
- 1.2. Эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгж: “Эрдэнэс Тавантолгой” ХК
- 1.3. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр: “Соёолон Инженеринг” ХХК
- 1.4. Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/303 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах журам”-ын 1.5-д заалт, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаал Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжаар томилогдсон Улсын комисс “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийг Улсын комисст хүлээлгэн өгөх тухай аж ахуйн нэгжийн 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/1081 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус компанийн уурхайн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу олборлолтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бичиг баримтын бүрдэлтэй танилцаад 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн №СТР/01 тоот “АЛБАН ДААЛГАВАР” өгч ажилласан.

ХОЁР. ШИЙДВЭР

- 2.1. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн №СТР/01 тоот Албан даалгаврын хэрэгжилтийг ирүүлсэн тул тус “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв”-ийн үйл

ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулахад шаардлагатай бүрдүүлбэл зохих бичиг баримтын бүрдэл бүрдсэн гэж үзээд “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах” Улсын комиссоос **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

2.1.1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв” нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/303 дугаар тушаалаар баталсан журмын 2.2-т заасны дагуу “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээлгэн өгөх бэлтгэл ажил”-ыг хангасан гэж үзэв.

2.1.2. “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв”-ийн үйл ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлэхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д зөвшөөрөв.

2.2. Улсын комиссоос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн удирдлагад чиглэл болгов.

ГУРАВ. УЛСЫН КОМИССЫН ЗӨВЛӨМЖ

- 3.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/205 дугаартай “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах;
- 3.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2020 оны А/155, А/132 дугаартай “Ашигт малтмалын баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах;
- 3.3. Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн тогтоосон түвшний хэм хэмжээг хэтрүүлж үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах;
- 3.4. Төслийн агаар мандал болон хүн, амьтан ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, тоосжилтыг бууруулах;
- 3.5. “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв”-д ажиллах хүчийг сургаж бэлтгэх, дадлагажуулах, технологийн горимыг чанд мөрдөх, нутагшуулахад онцгой анхаарч ажиллах;
- 3.6. Бүтээгдэхүүний журнал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр сайтар хөтлөх;
- 3.7. Тавантолгой төмөр зам ХХК нь зүгшрүүлэлтийн 1 жил болон баталгааны 3 жилийг гэрээнд заасны дагуу хариуцах;
- 3.8. Тос, тосолгооны материалыг аюултай хог хаягдлын цэгт хуримтлуулж гэрээний дагуу тээвэрлүүлж, устгуулах;
- 3.9. “Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв”-ийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах зэрэг болно.

УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Дарга:



М.Мэндбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны газрын дарга;

Гишүүд:

















УХАА

Б.Сандуйжав, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газрын Инженерийн байгууламжийн хяналтын хэлтсийн дарга;

С.Билгүүн, Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хяналт хариуцсан шинжээч, Улсын ахлах байцаагч;

Б.Мөнхбаяр, Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын Төмөр зам, гүүр, замын байгууламжийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн;

С.Дуламсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Улсын ахлах байцаагч;

П.Баасандорж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналтын газрын Барилгын техникийн хяналтын Улсын ахлах байцаагч;

З.Азжаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгаль орчны үнэлгээ аудитын хэлтсийн мэргэжилтэн;

Б.Должинсүрэн, Өмнөговь аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга, Улсын ахлах байцаагч;

Т.Зууннаст, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн дарга;

Д.Цолмонуяа, Ашигт малтмал, газрын тосны газрын Хайгуул, ашиглалтын газрын Уул уурхайн хэлтсийн мэргэжилтэн;

Я.Чулуун, Архивын ерөнхий газрын Зураг төслийн баримтын архивын эрхлэгч;

Ө.Нямаа, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Салбарын нүүрс баяжуулах үйлдвэрийн газрын дарга /тохиролцсоноор/;

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭ
БАЯЛГИЙН ЯАМ

УУРХАЙ, УУЛЫН БО
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР
АШИГЛАЛТАД ХҮЛЭ
АВАХ УЛСЫН КОМИ

9029294 СБТ 25957 9024








С.Гансүх, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төсөл, хөгжлийн газрын дарга /тохиролцсоноор/;


Б.Ганболд, “Бодь интернэшнл” ХХК-ийн Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн барилга угсралтын хэлтсийн захирал /тохиролцсоноор/;

О.Чинзориг, “Бодь интернэшнл” ХХК-ийн Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн төлөвлөгөө, мониторинг, гэрээний удирдлагын хэлтсийн захирал /тохиролцсоноор/.

Нарийн бичгийн дарга:



С.Пүрэвжал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны мэргэжилтэн;
А.Амарбуян, “Эрдэнэс тавантолгой” ХХК-ийн Ачилт, бутлалтын хэлтсийн удирдлага, хяналтын инженер /тохиролцсоноор/.



ҮНДЭСНИЙ ТӨВ АРХИВ

ЗУРАГ ТӨСӨЛ, ТЕХНИКИЙН БАРИМТ ХҮЛЭЭН АВСАН АКТ

2024 оны 09 дугаар
сарын 30-ны өдөр

№ 487

Улаанбаатар хот

Монгол Улсын Архив, Барилгын тухай хуулийг үндэслэн

"Бодь Интернэшнл ХХК" -ын

(Баримт шилжүүлсэн байгууллагын нэр, хөмрөгийн дугаар)

210 навтан баримт

(Баримтын дүн тоо)

материалыг УТА-ын ЗТБАрхивт хүлээн авлаа.

Үүнд:


№	Барилга байгууламжийн байршил, нэр	Зураг төсөл боловсруулсан байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Баримтын оны хязгаар	ХН- ээр	Хавтаст хэргээр	Кг- аар	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8	9
	Омноговь Интернэшнл Сэрмон Таван тол- гойн нирре ашиг Ломс ашиг Ломс ашиг Ломс Төв төсөл Дамс ашиг Бамс 1-4 ашиг	Сэрмон Интернэшнл ХХК (Т/м/с/т) (Tech gear) Beijing Co., Ltd	"Бодь Интернэшнл" ХХК	2021- 2024	—	210	—	—

Баримт хүлээлгэн өгсөн:

ТМГХХ Захирал О.Чинзориг

(Байгууллагын ажилтны албан тушаал, нэр, гарын үсэг)

88004909
(ТМГХХ захирал)



Баримт хүлээн авсан:

ЗТБАрхивын

Б.Оюунмартал

(Архивын ажилтны албан тушаал, нэр, гарын үсэг)